



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэшлээрээ бие даан мэргэшлийн санал, дүгнэлт гаргасан, тайлан бичсэн байх /гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувь, он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх ба аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн бол албан тоотын хувь ирүүлэх /;
2. Тухайн мэргэшлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх / батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судалгааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол жагсаалтыг гаргасан байх; /эх хувийг хавсаргах/;
4. Тухайн горилох мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдсан /жагсаалт гаргах, гэрчилгээний эх хувь ирүүлэх /.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэшлээрээ бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргасан, тайлан бичсэн, тушаал, журам, заавар, үндэсний хөтөлбөр боловсруулсан байх /гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувь, он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх ба аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн бол албан тоотын хувь ирүүлэх /;
2. Тухайн мэргэшлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх/ батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судалгааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол жагсаалтыг гаргасан байх. /эх хувийг хавсаргах/;
4. Тухайн горилох мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдсан жагсаалт гаргах /түүнийг нотлох баримт бол сургалтын сертификатын эх хувь/;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

5. Хоёроос доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургаж мэргэшил эзэмшүүлсэн байх /мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, хэзээ, хаана ямар тушаалаар сурсан баталгаажсан эх хувийг хавсаргах/;
6. Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх /зохиогчийн эрхийн гэрчилгээ байж болно/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэжлээрээ бие даан мэргэшлийн санал, дүгнэлт гаргасан, тайлан бичсэн, тушаал, журам, заавар, үндэсний хөтөлбөр, стратеги, хуулийн төсөл боловсруулсан байх /гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувь, он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн бол албан тоотын хувь ирүүлэх/;
2. Тухайн мэргэжлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх /батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судлагааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол жагсаалтыг гаргасан байх. /эх хувийг хавсаргах/;
4. Тухайн горилох мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдсан жагсаалт гаргах / сургалтын гэрчилгээний эх хувь хавсаргах/;
5. Таваас доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургаж мэргэшил эзэмшүүлсэн байх /мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, хэзээ, хаана ямар тушаалаар сурсан баталгаажсан эх хувийг хавсаргах/;
6. Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх./Зохиогчийн эрхийн гэрчилгээ байж болно/.